



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар

А/118

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэлийн шинжээч  
сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх  
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.18 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 23.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-д, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 247 дугаар тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 30 ны өдрийн  
А/... дугаар тушаалын хавсралт



## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээч (цаашид шинжээч гэх) сонгон шалгаруулах, шинжээчийг ажиллуулах, чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологи, чанарт хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргахаар томилогдсон мэргэжилтнийг эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээч гэнэ.

1.3. Магадлан итгэмжлэлийн шинжээч ажиллуулахтай холбогдох өдөр тутмын үйл ажиллагааг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн “Чанар, магадлан итгэмжлэлийн алба” (цаашид ажлын алба гэх) удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

### Хоёр. Шинжээч сонгон шалгаруулах

2.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ажлын албатай хамтран шинжээчийн сонгон шалгаруулалтыг 2 жил тутамд нээлттэй зарлаж явуулна.

2.2 Шинжээчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг сонгон шалгаруулалт явагдахаас 21 өдрийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

2.3 Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, их, дээд сургууль, эрүүл мэндийн байгууллагууд дараах шаардлагыг хангасан мэргэжилтнийг шинжээчид нэр дэвшүүлж болно:

2.3.1. Тухайн мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;

2.3.2. Анагаах ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэшлийн зэрэг, эсхүл эрдмийн цолтой;

2.3.3. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах, баримт бичиг боловсруулах чадвар, дадлага туршлагатай;

2.3.4. Эмнэлгийн удирдлага, тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдаж байсан, судалгаа шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;

- 2.3.5. Тасаг, нэгжийн эрхлэгчээс дээш удирдах албан тушаал эрхэлдэг эсвэл удирдаж байсан туршлагатай;
- 2.3.6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, эм хангамжийн байгууллага)-д удирдах албан тушаал эрхэлдэггүй;
- 2.3.7. Ёс зүй, харилцаа, хандлагын зөрчил гаргаж байгаагүй;
- 2.3.8. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

2.4. Шинжээчээр ажиллахыг хүсэгч дараах материалыг бүрдүүлж, ажлын албанд ирүүлнэ:

- 2.4.1. Төрийн албан хаагчийн анкет;
- 2.4.2. Өргөдөл;
- 2.4.3. Иргэний цахим үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.4.4. Дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, удирдлагын сургалтын гэрчилгээ, судалгаа шинжилгээний ажил, эрдмийн цол болон мэргэшлийн зэргийг нотлох баримтыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
- 2.4.5. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай, ажлын дадлага туршлага, тасралтгүй сургалтад хамрагдсан талаар тусгагдсан ажиллаж буй байгууллага, мэргэжлийн зөвлөл, нийгэмлэгийн тодорхойлолт;
- 2.4.6. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл (УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтаар);
- 2.4.7. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг;
- 2.4.8. Ёс зүйн салбар хорооны тодорхойлолт;

2.5. Ажлын алба нь нэр дэвшигчийн материалыг хүлээн авч бүртгэх ба материалын бүрдэлт дутуу эсхүл шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.

2.6. Энэ журмын 2.4-т заасан материалыг бүрдүүлж ирүүлсэн нэр дэвшигчийн ажлын туршлага, ур чадварыг харгалзан 2.3-т заасан шаардлагыг хангасан мэргэжилтний талаарх дүгнэлт, саналыг Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөл (цаашид зөвлөл гэх)-ийн хурлаар хэлэлцүүлж, сонгон шалгаруулна.

### **Гурав. Шинжээчийг томилон ажиллуулах**

3.1. Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сонгон шалгаруулалтад тэнцсэн шинжээчийг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 2 жилийн хугацаагаар томилж, шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага, шинжээчид мэдэгдэнэ.

3.2. Ажлын алба нь шинжээчийг нэр дэвшүүлсэн байгууллага, шинжээчтэй гэрээ байгуулж, шинжээчид үнэмлэх олгоно. Шинжээчтэй байгуулах гэрээний загварыг Зөвлөлийн дарга батална.

3.3. Ажлын алба нь шинжээчид тусгай дугаар өгч, эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийх хуваарийг урьдчилан гаргаж батлуулна.

3.4. Шинжээч дараах чиг, үүргийг хэрэгжүүлнэ.

3.4.1 Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан эрүүл мэндийн байгууллагад батлагдсан хуваарийн дагуу ажиллана.

3.4.2 Үнэлгээ хийх эрүүл мэндийн байгууллагын ирүүлсэн материалтай урьдчилан танилцаж, мэдээлэл авсан байна.

3.4.3 Шинжээч нь багаар ажиллаж, магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийн дагуу бодит нөхцөл байдлыг үнэн, зөв үнэлж, дүгнэлт гаргахад тэгш эрхтэй оролцоно.

3.4.4 Үнэлгээний явцад шаардлагатай зарим нэмэлт мэдээлэл, материалыг тухайн байгууллагаас гаргуулж авч болно.

3.4.5 Үнэлгээ, дүгнэлттэй холбогдох баримт бичгийг боловсруулж, хугацаанд нь багийн ахлагчид хүлээлгэн өгнө.

3.4.6 Багийн ахлагч нь багийн гишүүдийг чиглүүлж, чиг үүргийг хуваарилан үнэлгээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

3.4.7 Багийн ахлагч гишүүдийн боловсруулсан баримт бичгийг хянан үзэж, баталгаажуулан, журамд заасан хугацаанд ажлын албанд хүлээлгэн өгнө.

3.4.8 Шинжээч нь ажлын албаны заавар, зөвлөмжийн дагуу ажиллаж, үнэлгээний дүгнэлтийг зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэлийг хангана.

3.4.9 Шинжээч нь салбарын хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг судлах, тусламж үйлчилгээний шинэ технологи, арга, аргачлалын талаар мэдээлэл олж авах, тасралтгүй суралцаж, өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.

3.4.10 Зөвлөл, ажлын албанаас өгөх зөвлөмжийг хэрэгжүүлэх, зохион байгуулагдах сургалт, хэлэлцүүлэг, уулзалт болон бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, санал хүсэлтээ илэрхийлнэ.

3.4.11 Шинжээч нь ажил үүргийн дагуу байгууллага болон хувь хүний нууцлалтай холбоотой олж авсан мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглах, задруулахыг хориглоно.

3.4.12 Шинжээч нь байгууллага, хувь хүнд хүндэтгэлтэй хандаж, хувийн соёлыг дээдлэн ажиллана.

3.5. Байгууллагад үнэлгээ хийх тохиолдол бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл бичгээр өгнө.

3.6. Шинжээч нь үнэлгээ хийх эрүүл мэндийн байгууллагатай ашиг сонирхлын болон үйл ажиллагааны харилцаа холбоогүй байх шаардлагатай. Хэрэв ийм зөрчил үүссэн тохиолдолд шууд татгалзаж, ажлын албанд мэдэгдэнэ.

3.7. Шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага нь шинжээчийг томилолтын хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлөх үүрэг хүлээнэ.

3.8. Шинжээчийн эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийсэн хугацаа, ажлын үр дүнг нь харгалзан холбогдох журам, үйлчилгээний зардлын жишигт заасан дагуу ажлын хөлс олгоно.

3.9. Шинжээч нь үнэлгээг мэргэжлийн өндөр түвшинд хийж, харилцаа, хандлага, ёс зүйн зөрчил гаргаагүй бол шинжээчээр дахин ажиллах хүсэлтээ 1 удаа гаргаж болно.

3.10. 3.9-д заасан шаардлагыг хангасан шинжээчийн хүсэлт, ажлын үр дүнг харгалзан Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн шинжээчийн эрхийг 2 жилээр нэг удаа сунгана.

3.11. Хоёр жил тутам шинжээчдийн гуравны нэг шинэчлэгдэж байх ба энэхүү журмын 3.10-т заасны дагуу томилогдож ажилласан шинжээч 3 жил завсарласны дараа дахин шинжээчээр ажиллах хүсэлт гаргаж болно.

3.12. Шинжээчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргаснаас учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

3.13 Ажлын алба нь шинжээчийн орон нутаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, аюулгүй байдлыг хангаж дэмжлэг үзүүлж ажиллахаас гадна шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлыг зохион байгуулна.

#### **Дөрөв. Шинжээчийг чөлөөлөх**

4.1. Шинжээчийг дараах тохиолдолд чөлөөлж, шинжээчтэй хийсэн гэрээг цуцална:

4.1.1. Өөрийн хүсэлтийг үндэслэн;

4.1.2. Мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;

4.1.3. Гэрээний заалт зөрчсөн.

-----oOo-----